



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар хийгдсэн аудитын тайлан

АУДИТЫН НЭР: ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН



**АУДИТЫН ДҮГНЭЛТ: ТӨРИЙН САНГИЙН ТӨЛБӨР ТООЦООНЫ
ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.**

АГУУЛГА

<u>ТАЙЛАН</u> <u>БЭЛТГЭСЭН</u> Архангай аймаг дахь төрийн Аудитын газар Тэргүүлэх аудитор Д.Уламбаяр Аудитын менежер Т.Байгалмаа Ахлах аудитор Ж.Мөнгөншагай Аудитор Н.Энхчимэг Ш.Лхамноржмаа 2018 оны 11 сар Уг тайланг Аймгийн Аудитын газрын Вэб сайт-аас үзнэ үү. www.ar-audit-com Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах асууж лавлах зүйл байвал 70332860, 70333019 дугаарын утас, 70333141 дугаарын факсаар харилцана уу, Хаяг: Эрдэнэбулган сум Аймгийн ЗДТГ-ын байр 3-р давхар 313 тоот	ТОВЧ ҮГИЙН ТАНИЛЦУУЛГА АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ ОРШИЛ <u>Дэд зорилт – 1</u> А. Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагаанд мөрдөж буй хууль эрх зүйн заалтууд хоорондоо уялдахгүй байна. <u>Дэд зорилт – 2</u> Б. Төрийн сангийн төлбөр тооцооны журмын хэрэгжилт хангалтгүй байна. АУДИТЫН ДҮН АУДИТЫН ДҮГНЭЛТ АУДИТЫН САНАЛ АУДИТЫН ЗӨВЛӨМЖ
---	---

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

УИХ	Улсын их хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗГСУМС	Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн систем
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ЗГ	Засгийн газар
СА	Санхүү алба
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ОНХС	Орон нутаг хөгжлийн сан

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

1. Аудитын нэр:

Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүнд хийх аудит

2. Аудитын код:

ҮАГ-САГ-/2018/03-СА

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төсвийн Байнгын хорооны 2017 оны “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын а/06 дугаар тушаалаар баталсан Үндэсний Аудитын газрын 2018 оны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон орон нутгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

4. Аудитын зорилтууд:

Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааг явуулахдаа өөрийн нөөцийг үр ашигтай ашиглаж дэвшүүлсэн зорилго, зорилтоо хэрхэн биелүүлж хэрэглэгч үйлчлүүлэгчийн хэрэгцээ шаардлагыг хэрхэн хангаж байгаад үнэлэлт дүгнэлт өгч үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Төрийн сангийн нэгдсэн тогтолцоо оновчтой зохион байгуулагдсан эсэх
- Төрийн сангийн үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх

4. Аудитын хамрах хүрээ:

Аудитыг Төрийн сангийн 2017 оны үйл ажиллагаатай холбоотой баримт материалд тулгуурлан гүйцэтгэх бөгөөд аймаг, сумдын төрийн сан, төсвийн байгууллагуудыг хамруулан шалгалаа.

5. Аудитын арга зүй:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталсан гүйцэтгэлийн аудитын журмын дагуу Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, тогтоол, түүнийг дагалдан гарсан эрх зүйн актуудын хүрээнд хэрэгжүүлэгч байгууллага, нэгжийн холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, хүрсэн үр дүнг үндсэн үзүүлэлттэй харьцуулах, цуглуулсан судалгаа, шинжилгээний баримт материалд дүн шинжилгээ хийх зэргээр Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан аудитын дэд төлөвлөгөөний арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр горимын дагуу шаардлагатай нотлох зүйлсийг цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

6. Аудитад ашиглах шалгуур үзүүлэлт:

Дараах хууль, тогтоомжийг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав: Хуулиуд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол улсын 2017 оны Төсвийн тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Өрийн удирдлагын тухай хууль болон бусад холбогдох хуулиуд.

Засгийн газрын тогтоол:

- Төрийн сангийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх тухай-2013
- Санхүүгийн алба байгуулах тухай-2014
- Төрийн сангийн үйл ажиллагааны журам-2015

Сангийн сайдын тушаал:

- Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам-2012
- Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам- 2012
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт зохицуулалт хийх, Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам-2013
- Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг Монголбанк, арилжааны банкинд нээх, хаах журам-2013
- Төрийн сангийн нэгдсэн дансны чөлөөт эх үүсвэрийг удирдах журам-2014
- Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам-2014
- Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх журам- 2014
- Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн төлөвлөлтийн журам-2014
- Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар-2015
- Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам-2016
- Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам болон бусад холбогдох хууль, журмуудыг ашиглана-2017

7. Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Д.Уламбаяр удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер Т.Байгалмаа хэрэгжүүлж, ахлах аудитор Ж.Мөнгөншагай, аудитор Н.Энхчимэг, гэрээт ажилтан Ш.Лхамноржмаа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

8. Аудитын хугацаа:

Аудитын төлөвлөлтийн өмнөх болон төлөвлөлтийн үе шатны ажлыг 2018 оны 8 дугаар сарын 27-ноос, талбарын ажлыг 9 дүгээр сарын 05-наас, тайлагналын үе шатны ажлыг 10 дугаар сарын 15-наас тус тус эхлэн аудитын тайланг ҮАГазарт 2018 оны 11 дүгээр сарын 01-ны өдөр хүргүүлнэ.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд : Үүнд:

- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол улсын 2017 оны төсвийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Аймаг, сумын ИТХ-ын хуралдааны тогтоолууд
- Холбогдох бусад хууль тогтоомж
- Сангийн сайдын 2012 оны 76 р тушаалаар баталсан Төсвийн төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журам

9. Аудитын явцад үүссэн хүндрэл бэрхшээл:

Аудитаар 19 сумын төрийн сангийн үйл ажиллагааг төлбөр тооцооны анхан шатны баримтаар үүнээс 13 суманд газар дээр нь очиж шалгах явцад Өгийнуур сумын төрийн сангийн мэргэжилтний үйл ажиллагааны хяналт, ажлын хариуцлагатай холбоотой алдаа дутагдлууд нилээд илэрсэн бөгөөд тухайн суманд ажилласан ажлын хэсгийн дүнгийн хурлаар дэлгэрэнгүй танилцуулагдаж, харилцан ойлголцсон байтал, сумын удирдлагууд, төрийн сангийн мэргэжилтэн нар хүргүүлсэн асуудлыг бүртгэлийн хариуг ирүүлэхгүй хугацаа хоцроох, ирүүлсэн хир нь хүлээн зөвшөөрөхгүй, алдаа зөрчил гаргаагүй гэх тайлбар гаргах зэргээр аудитын үйл ажиллагаанд хүндрэл үүсгэж, аудитын байгууллагыг үл хүндэтгэсэн үйлдэл гаргаж байлаа.

НЭГ. ОРШИЛ

Монгол улсын Засгийн газрын “Төрийн сангийн тогтолцоонд шилжих тухай” 2002 оны 101 дүгээр тогтоолоор Монгол Улсын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн албаны бүтцийг төрийн сангийн тогтолцоонд шилжүүлсэн байна. Мөн Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолоор санхүүгийн албаны зохион байгуулалт чиг үүрэг, орон тооны жишиг нормативыг баталсан бөгөөд 18 суманд санхүүгийн алба байгуулагдаж 100 шахам албан хаагчид ажиллаж байна.

Аймгийн Төрийн сангийн хэлтэс нь аймаг орон нутгийн хэмжээний үйлдвэр, аж ахуйн газар, албан байгууллага хөдөө аж ахуй, эдийн засгийн албыг бэхжүүлэх, дотоод нөөц бололцоог бүрэн дүүрэн ашиглах, арвилан хэмнэх эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх төсвийн орлогын төлөвлөгөөг ханган биелүүлэх, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг бүрэн хөтлүүлж, тооллого тооцооны ажлын чанарыг сайжруулж, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт зарцуулалтанд тавих хяналт мөн санхүү төсвийн сахилга батыг сайжруулах зэрэг ажлыг хариуцан гүйцэтгэж байна.

**ДЭД ЗОРИЛТ 1. ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ҮЙЛ АЖИЛЛАГААНД
МӨРДӨЖ БУЙ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗААЛТУУД ХООРОНДОО
УЯЛДАХГҮЙ БАЙНА.**

1.1 Төрийн сангийн тогтолцоо, чиг үүргийн талаар :

Төрийн сангийн тогтолцоо, чиг үүргийг Монгол улсын **Төсвийн тухай** хуулийн 36, 37 дугаар зүйлд тодорхойлж өгсөн бөгөөд зохион байгуулалтыг авч үзвэл дараах хэлбэртэй байна.

Төрийн сангийн бүтэц зохион байгуулалтыг авч үзвэл:

Сангийн яаманд

Төв төрийн сан

Аймаг, нийслэл

Санхүү төрийн сангийн хэлтэс

Сум, дүүрэг


Санхүүгийн алба

Засгийн газрын 2002 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 101 тоот тогтоолоор аймагт Засаг даргын Тамгын газрын төрийн сангийн хэлтэс, сумын төрийн сангийн төлөөлөгч гэсэн бүтцээр хэрэгжүүлж байхаар заасны дагуу

аймгийн Засаг даргын 2002 оны 6 дугаар сарын 19-ны өдрийн 183 тоот захирамжаар Төрийн сангийн хэлтсийн бүтцийг тогтоожээ.

Аймгийн Засаг даргын 2016 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн а/475 тоот захирамжаар Тамгын газрын бүтэц орон тоог шинэчлэхдээ СТХСэлтсийг 9 орон тоотой байхаар баталжээ.

Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн бүтэц:



Харин сумдын Санхүүгийн үйлчилгээ үзүүлэх албадыг Монгол улсын Засгийн газрын 2014 оны 326, 2015 оны 426-р тоот тогтоолууд, Сангийн яамны 4-3/6495 тоот зөвлөмж, аймгийн Засаг даргын 2014 оны 1/1705 тоот албан бичгийн дагуу 4 хүний бүрэлдэхүүнтэй байгуулах шийдвэр гарсан ч улмаар 5 хүний орон тоотой ажиллаж байна.

Сумдын санхүү албаны бүтэц:



Аймгийн төвийн сум болох Эрдэнэбулган суманд Засгийн газрын 2015 оны 426 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлд **“Аймгийн төвийн сум болон 8001-ээс**

дээш хүн амтай сумын Санхүүгийн албаны орон тооны дээд хязгаар 3 байхаар тогтоосугай” гэсэн заалтын дагуу Санхүүгийн албыг 2017 онд зохион байгуулаагүй, харин 2018 онд тус албыг бий болгож, 2 хүний орон тоотойгоор ажиллаж байна.

1.2 Төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжуудын талаар:

Төрийн сангийн үйл ажиллагааг Төсвийн тухай хуулиар зохицуулсан бөгөөд түүнтэй нийцүүлэн гарсан журмын зарим заалтууд нь хуулийн холбогдох заалттай зөрчилдөж байна. Үүнд:

- Төрийн сангийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалтын талаар Засгийн газрын 2015 оны 426 дугаар тогтоолын 2.1-д **“сумын ЗДТГ-ын санхүү алба нь дараах төсвийн байгууллагууд болон ОНХС, тусгай сангууд засаг даргын нөөц хөрөнгийг хариуцсан нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх 2 нягтлан бодогчтой байна”**, 2.2-д **“Хэрэв суманд дээр дурьдснаас олон орон тооны төсвийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бол ажлын ачааллыг харгалзан 3-5 төсвийн байгууллагын дунд 1 нягтлан бодогчтой байхаар орон тооны нормативыг тогтоох бөгөөд хариуцаж байгаа байгууллагуудын төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг хийж, тэдгээрт нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлнэ”** гэж сумдын төсвийн байгууллагын нягтлан бодогчдын орон тоог зааж өгсөн нь төсөвт байгууллага бүр нягтлан бодогчтой байхаар заасан байхад Төсвийн тухай хуулийн 19.3 **“Энэ хуулийн 19.1, 19.2-т зааснаас бусад тохиолдолд төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагч, шууд захирагч нь төсвийн ахлах нягтлан бодогч, нягтлан бодогчтой байна”** гэсэн заалттай уялдахгүй байна.
- Сангийн сайдын 2014 оны 95 тоот тушаалаар батлагдсан “Засгийн газрын удирдлагын мэдээллийн системд мөрдөх журам”-ын **3.3-т “10”...сумын санхүү албаны дарга буюу сумын төсвийн ерөнхий нягтлан бодогч, 3.4-т “11”... сумын төсөв, төрийн сангийн мэргэжилтний ажил үүргийн хуваарийг хариуцсан байгууллагын хүрээнд тодорхойлсон** байхад 5.9-д журмын 3 дугаар зүйлд заасан **эрхүүдийг нэг албан тушаалтанд давхардуулан олгохгүй бөгөөд өөрт оногдсон эрхээс өөр эрхээр системд нэвтэрч ажил үүрэг гүйцэтгэхийг хориглоно. Журмын энэхүү заалт нь сумын санхүүгийн албаны албан тушаалтанд хамаарахгүй болно**” гэсэн нь сумын Төрийн сангийн мэргэжилтэн, Санхүү албаны даргын албан тушаалыг 1 хүн хийж болохоор зааж өгсөн байна.

Иймд дээрх хуультай зөрчилдөж буй журмын заалтуудыг эргэн харж хуульд нийцүүлэх саналыг аудитын тайлангаар Сангийн яаманд уламжлаад байна.

1.3 Төрийн сангийн үйл ажиллагааны талаар:

Аймгийн хэмжээнд Төрийн сангийн хэлтэс болон сумдын санхүү албанд нийт 47 н ажилтан ажиллаж байна. Үүнээс аймгийн СТСХэлтэст-9, сумдад САДарга, төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн нийт 38 –н ажилтан ажиллаж байна.

Аймгийн СТСХэлтсээр 48 байгууллага, сумдын Санхүүгийн албаар 138 байгууллага нийт 186 төсвийн байгууллага төрийн сангаар төсвийн орлого, зарлагын гүйлгээ хийлгэн үйлчилгээ авч байгаа бөгөөд эдгээр байгууллагад *125 нягтлан бодогч* ажиллаж байгаа тоон мэдээ байна. Тодруулбал: Аймгийн төвийн сумын төсвийн байгууллагууд тус бүр дээ бие даасан 1 нягтлан бодогчтойгоор санхүү бүртгэлийн ажлыг гүйцэтгэж байгаа бол хөдөө сумдын төсвийн байгууллагуудын тухайд байгууллага бүр бие даасан нягтлан бодогчгүй, нэг нягтлан бодогч 2-3 байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг хариуцан ажиллаж байгаа нь нягтлан бодогчдын ажлын ачаалал хэт ихсэж төсвийн сахилга хариуцлага, тухайн байгууллагуудын хөрөнгө, санхүү бүртгэлд тавих хяналт суларсан байна. Үүнээс болж нэг нягтлан бодогчийн гаргаж байгаа алдаа нь хариуцаж байгаа байгууллагуудаас нэгэн адил илэрч өөрөөр хэлбэл нэг зөрчил 2-3 “үржиж”, өмч хөрөнгө шамшигдах, төсвийн сахилга бат алдагдах, байгууллагын дотоод мэдээлэл алдагдах гэх мэт эрсдэлүүд үүсэж байна.

Иймд сумдын төсвийн байгууллагуудыг бие даасан нягтлан бодогчтой болгох зайлшгүй бодит хэрэгцээ шаардлага байна гэж үзэн саналыг Сангийн яаманд аудитын тайлангаар уламжилж байна.

1.4 Төрийн сангийн ажилтнуудын чиг үүрэг, ажлын байрны тодорхойлолтын талаар:

Сангийн сайдын 2015 оны 90-р тушаалаар Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг зааврыг баталсан байна. Аймгийн СТСХэлтэс, болон 18 сумдын Санхүү албаны ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод дээрх тушаалаар баталсан чиг үүргийг бүрэн тусгажээ.

Аудитад хамрагдсан 18 сумын, санхүү албаны дарга, төлбөр тооцооны мэргэжилтнүүдийн ажлын туршлага, ажилласан жил, мэргэжлийг судалгаагаар харуулбал:

Хүснэгт1: Сумдын санхүү албаны дарга, төлбөр тооцооны мэргэжилтний судалгаа

№	Сумдын нэр	Санхүүгийн мэргэжилтэй		Улсад ажилласан жил дундаж		Тухайн албан тушаалд	
		Дарга	Мэргэжилтэн	Дарга	Мэргэжилтэн	Дарга	Мэргэжилтэн
1	Батцэнгэл	тийм	тийм	27	4	3	0.3
2	Булган	тийм	тийм	13	1	3	1
3	Жаргалант	тийм	үгүй	11	17	1	3
4	Ихтамир	тийм	тийм	28	28	3	3
5	Өгийнуур	тийм	тийм	0	30	0	3
6	Өлзийт	тийм	тийм	9	0.3	3	0.3
7	Өндөр-Улаан	тийм	тийм	21	1	3	1
8	Тариат	тийм	тийм	13	1	0.3	0.9
9	Төвшрүүлэх	тийм	тийм	5	33	0.1	3
10	Хайрхан	тийм	тийм	22	1	3	1
11	Хашаат	тийм	тийм	25	11	3	3
12	Хотонт	тийм	тийм	6	4	1	0.8
13	Цахир	тийм	тийм	23	26	3	3
14	Цэнхэр	тийм	тийм	36	3	3	3
15	Цэцэрлэг	тийм	тийм	34	5	3	2
16	Чулуут	тийм	тийм	6	13	3	3
17	Эрдэнэбулган	тийм	тийм	5	19	0.2	0.2
18	Эрдэнэмандал	тийм	тийм	27	13	3	3

Судалгаанаас харвал:

Санхүү албаны дарга нарын хувьд

- Тухайн албан тушаалд 3 жил ажилласан санхүү албаны дарга 12,
- 1 хүртэл жил ажилласан санхүү албаны дарга 5

Мэргэжилтний хувьд

- 3 жил ажилласан 9,
- 2 хүртэл жил ажилласан 9 төрийн сангийн мэргэжилтнүүд байна.

Сумдын Санхүү албанд ажиллаж байгаа дарга, төлбөр тооцооны мэргэжилтнүүд нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэй байна.

Аудитаар сумдын санхүү албаны төрийн сангийн ажилтнуудын ажлын чиг үүрэг, ажлын байрны тодорхойлолтын дагуу тавигдах шаардлага, шалгуурыг хэрхэн хангаж байгаа байдлыг шалгахад дараах зөрчил илэрлээ . Үүнд:

1. Өгийнуур суманд Санхүү албаны даргын үүрэгт ажлыг эрхэлсэн албан тушаалтан томилогдоогүй 2 жил болж байхад уг албан тушаалыг төрийн сангийн төлбөр тооцооны мэргэжилтэн хавсран гүйцэтгэж байна.
2. Жаргалант сумын Санхүү албаны төлбөр тооцооны мэргэжилтнийг ажилд авахдаа ажлын байрны тодорхойлолтын шалгуур үзүүлэлтийг тухайн ажилтанд тохируулан гаргаж, хүний нөөцийн мэргэжлээр төгссөн хүн ажиллаж байна.

Эндээс үзэхэд аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн даргын зүгээс ажил үүргийн жишиг зааврын дагуу дээрхи сумдын санхүүгийн албаны үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээгээр хангаж ажиллаагүй байна гэж үзэхэд хүргэж байна.

1.5 Аймгийн Санхүү төрийн сангийн үйл ажиллагааг үр нөлөөтэй явуулах стратеги төлөвлөгөө, хөтөлбөрийн талаар:

Стратеги төлөвлөгөөнд дараах зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд:

1. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах.
2. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах
3. Аймгийн санхүү, эдийн засаг, төсвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах
4. Санхүү эдийн засгийн бодлогын хэрэгжилтэнд хяналт шинжилгээ хийх, үнэлгээ өгөх гэсэн зорилттой байна.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь стратеги төлөвлөгөөнд тусгагдсан дээрх зорилтууд болон аймгийн Засаг дарга, тамгын газрын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний дагуу 2017 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг гарган уг төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу ажилласан үр дүнг аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний дагуу үнэлсэн байна.

ДЭД ЗОРИЛТ 2. ТӨРИЙН САНГИЙН ТӨЛБӨР ТООЦООНЫ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

2.1 Төрийн сангийн төлбөр тооцооны чиг үүрэг, төсөв, мөнгөн хөрөнгийн удирдлага, зохицуулалтыг хууль тогтоомжийн дагуу үр нөлөөтэй гүйцэтгэж байгаа талаар:

Аймгийн хэмжээнд төрийн сангаар 2017 онд давхардсан тоогоор 2967 дансаар 109,412.2 сая төгрөгийн зардлыг 50190 гүйлгээгээр шивж баталгаажуулсан байна. Үүнээс үзэхэд төрийн сангийн мэргэжилтэн өдөрт дунджаар 9-10 гүйлгээг шивдэг, ажлын ачаалал бага мэт харагдах боловч санхүүжилтийн эрх нээгдсэнтэй холбоотойгоор өдөр, өдрийн ачаалал харилцан адилгүй байдаг байна.

Хүснэгт-3 Аймаг, сум дахь төрийн сангийн харьяа байгууллагын зарлагын гүйлгээний нэгдсэн судалгаа Б.1.1.3

№	Сар	Төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтний тоо	Бүртгэлийн дансны тоо	Нийт гүйлгээний тоо			
				Тоо	Нийт дүнд эзлэх хувь	Мөнгөн дүн /төгрөгөөр/	Нийт дүнд эзлэх хувь
A	2017	20	2,967	50,190	100.00	109,412,228,277.94	100.00
1	1 сар	20	225	1,622	3.23	5,086,884,222.44	4.6
2	2 сар		236	3,851	7.67	9,581,746,085.23	8.8
3	3 сар		230	3,878	7.73	8,272,285,119.87	7.6
4	4 сар		230	3,878	7.73	7,748,461,821.18	7.1
5	5 сар		238	4,606	9.18	7,901,443,310.42	7.2
6	6 сар		263	6,148	12.25	12,973,452,894.26	11.9
7	7 сар		244	3,311	6.60	6,849,450,111.69	6.3
8	8 сар		234	3,349	6.67	5,830,339,215.46	5.3
9	9 сар		258	3,778	7.53	8,202,822,634.11	7.5
10	10 сар		261	4,192	8.35	8,780,185,256.76	8.0
11	11 сар		260	4,400	8.77	9,700,530,821.51	8.9
12	12 сар		288	7,177	14.30	18,484,626,785.01	16.9

Дээрхи хүснэгтээс харахад жилийн 6, 11, 12 саруудад нийт гүйлгээний дийлэнх хувь нь / 37.7% / гарч байгаа бөгөөд энэ саруудад төрийн сангийн мэргэжилтний ажлын ачаалал ихсэж байгаа судалгаа харагдаж байна.

Төрийн сангийн төлбөр тооцоог хууль журмын дагуу аюулгүй, үнэн зөв, түргэн шуурхай явуулж байгааг 18 сумын төрийн сангийн төлбөр тооцооны баримт болон аймаг, сумдын 92 төсөвт байгууллагуудын 6,11,12 сарын **16,322.0 сая төгрөгийн 8728** ширхэг төлбөрийн хүсэлт, **23826** ширхэг анхан шатны баримтаар тулган шалгалаа. (Аудитаар тухайн сум болон аймгийн төвийн ЗДТГ, ЕБС, Дунд сургууль, Хүүхдийн цэцэрлэг, ЭМТ, Сум дундын эмнэлэг гэх мэт төсөв ихтэй байгууллагуудыг хамруулан шалгасан)

Аудитаар дараах зөрчил дутагдал илэрлээ.

Хүснэгт 2: Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл


№	Сумын нэр	Түүвэрт хамруулсан			Төлбөрийн хүсэлтийн мөнгөн дүн /сая төг/	Шаардлага хангаагүй баримтын тоо		Зөрчлийн дүн /сая.төг/	Нийт алдааны дүнд эзлэх хувь
		Байгууллагын тоо	Тхүсэлт	АШБ тоо		Тхүсэлт	АШБ		
1	Батцэнгэл	4	429	1462	547.8	1	5	2.1	0.1
2	Булган	5	323	579	424.8	156	2	122.2	7.5
3	Жаргалант	4	326	1214	715.8	12	314	209.6	12.9
4	Ихтамир	4	351	768	746.2	16	13	104.2	6.4
5	Өгийнуур	5	643	1006	896.9	330	4	430.7	26.5
6	Өлзийт	4	359	610	482.1	132	59	65.6	3.9
7	Өндөр-Улаан	5	427	1145	728.4	13	25	110.9	6.8
8	Тариат	5	463	1386	804.2	4	56	93.9	5.8
9	Төвшрүүлэх	4	199	600	180.6	7	12	2.2	0.1
10	Хайрхан	4	393	951	673.5	50	53	70.8	4.3
11	Хашаат	4	444	943	528.9	7	9	22.2	1.4
12	Хотонт	6	433	1206	890.7	43	9	101.1	6.2
13	Цахир	4	296	827	419	32	0	14.9	0.9
14	Цэнхэр	4	298	861	766.6	14	7	23.5	1.4
15	Цэцэрлэг	4	289	1003	726.8	4	24	16.4	1
16	Чулуут	5	468	1203	722.3	23	0	17.6	1.1
17	Эрдэнэбулган	7	872	2545	2,286.60	63	19	134.6	8.3
18	Эрдэнэмандал	4	385	1293	936.9	4	48	5.4	0.6
18	Сумын дүн	82	7398	19602	13,478.1	911	659	1,570.0	95.2
1	Аймаг	12	1330	4224	2,843.9	77	0	77.7	4.8
19	Нийт дүн	94	8728	23826	16,322.0	988	659	1,625.8	100

Алдаа зөрчлийн нэгтгэлээс үзэхэд 8728 ширхэг төлбөрийн хүсэлтээс 988 ширхэг шаардлага хангаагүй төлбөрийн хүсэлтээр гүйлгээ хийсэн, 23826 ширхэг

анхан шатны баримтаас 659 ширхэг шаардлага хангаагүй болон төрийн сангийн мэргэжилтэн хянаж тэмдэг дараагүй гүйлгээ хийсэн нийт 1647 ширхэг буюу 1,625.8 сая төгрөгийн гүйлгээтэй холбоотой алдаа зөрчил илэрсэн.

Дээрх зөрчил дутагдал нь Төрийн сангийн үйл ажиллагааны журмын дараах заалтуудыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой илэрсэн. Үүнийг графикаар харуулбал.

График-1 “Төрийн сангийн үйл ажиллагааны журмын зөрчигдсөн заалттай холбоотой судалгаа ” мөнгөн дүн /сая.төг/



Үүнээс үзэхэд: Нийт зөрчлийн 64% нь журмын 8.6, 8.7 дахь заалт буюу төрийн сангийн мэргэжилтэн гүйлгээ хийхдээ хяналтын хуудсанд үндэслэн анхан шатны баримтыг хянаж, баталгааны тэмдэг дараагүйтэй холбоотой байна.

- Журмын 7.5-7.7 дахь заалтуудыг зөрчин хүчин төгөлдөр болон иж бүрэн мэдээлэлтэй төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтээр гүйлгээ хийгээгүй 12 сумын 33 төсөвт байгууллагын 235.9 сая төгрөгийн 232 ширхэг баримт,
- Журмын 7.11, 7.12 дахь заалтуудыг дагаж мөрдөлгүй орлого бууруулах гүйлгээг хийхдээ нотлох баримтыг бүрэн хавсаргаагүй гүйлгээ хийсэн 3 сумын 4 төсөвт байгууллага болон аймгийн төвийн 3 төсөвт байгууллагын нийт 20.6 сая төгрөгийн 18 ширхэг төлбөрийн хүсэлт,
- Буруу шивсэн, баталгаажаагүй зарлагын гүйлгээг залруулахдаа журмын 7.14 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй 9 сумын 11 төсөвт байгууллагын 20.0 сая төгрөгийн 21 баримт,
- Журмын 8.2, 8.10 дахь заалтуудыг зөрчин ажлын 3 хоногоос хэтрүүлэн гүйлгээ хийсэн 5 сумын 10 төсөвт байгууллага болон аймгийн төвийн 2 төсөвт байгууллагын нийт 169.7 сая төгрөгийн 74 төлбөрийн хүсэлт,
- Журмын 8.4 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй 10 сумын 18 төсөвт байгууллага болон аймгийн төвийн 2 төсөвт байгууллагын нийт 139.0 сая төгрөгийн 212 баримт,

- Журмын 8.6, 8.7 дахь заалтыг зөрчин төлбөрийг гүйцэтгэхдээ үндэслэх баримтуудыг хяналтын хуудастай тулган төрийн сангийн тэмдэг дарж, баталгаажуулаагүй 19 сумын 60 төсөвт байгууллага, 2 сумын санхүү төрийн сангийн хэлтэс болон аймгийн төвийн 3 төсөвт байгууллагын нийт 1,040.6 сая төгрөгийн 1090 баримттай холбоотой тус тус алдаа зөрчлүүд илэрсэн.

Дээрх илэрсэн зөрчлүүдийг үзэхэд төрийн сангийн төлбөр тооцоонд баримтлах журмын заалтуудыг бүрэн хангаж ажиллахгүй байна .

Иймд Сумдын санхүү албаны ажилтнуудад төрийн сангийн төлбөр тооцооны журмын хэрэгжилтийг хангаж ажиллах, тэдний үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах арга хэмжээ зохион байгуулах шаардлагатай байна.

Сумдын төрийн сангийн мэргэжилтний тамга тэмдгийн хадгалалт хамгаалалтыг шалгахад СТСХэлтсийн ажилтнуудын нэгдсэн тамга тэмдгийн судалгаагаар 39 тамга тэмдэг эзэмшигч байна. Аудитаар Жаргалант, Эрдэнэмандал сумдын санхүү албаны төлбөр тооцооны мэргэжилтний тамга тэмдгийн хадгалалт хамгаалалт сул ширээний нүдэнд хийдэг тухайн ширээ нь цоож, лацгүй байсан зөрчил илэрсэн. Энэ нь Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 12.5-д **“Тэмдэг, баталгааны тэмдгийн бүрэн бүтэн байдал, хадгалалт, хамгаалалтыг тухайн эзэмшигч хариуцна”** гэсэн заалтыг зөрчсөн, тухайн тамга тэмдгийг зориулалт бусаар ашиглах, алдагдах эрсдэл үүсгэсэн нөхцөлийг бий болгож байсан тул аудитаас зөрчлийг арилгуулах албан шаардлагыг сумдын Засаг дарга, Санхүү албаны дарга, Төрийн сангийн мэргэжилтэн нарт хүргүүллээ.

Өгийнуур сумын төрийн сангийн төлбөр тооцооны үйл ажиллагаанд хийсэн аудитаар Төрийн сангийн мэргэжилтэн ээлжийн амралтаа эдлэх хугацаандаа ЗГСУМС-д мөрдөх журмын 2.4 дахь заалт ¹, 2.7 дахь заалтуудыг ² тус тус дагаж мөрдөлгүй системд нэвтрэх хэрэглэгчийн нэр, нууц үг, баталгааны тэмдгийг албан ёсоор шилжүүлэх шийдвэр гараагүй байхад 6 төсөвт байгууллагын 2017, 2018 оны 389.3 сая төгрөгийн 306 төлбөрийн хүсэлтэнд тухайн сумын нягтлан бодогч баталгааны тэмдгийг ашиглан гүйлгээ хийсэн зөрчил илэрсэн.

Аудитаас Төрийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналыг хүргүүлсэн боловч зөрчил,

¹ 2.4-д “... ээлжийн амралт,...системийн нэр, нууц үгээ шилжүүлэх тохиолдолд харьяа нэгжийн удирдах албан тушаалтны холбогдох тушаал шийдвэрийг үндэслэн эрхийг шинэ хэрэглэгчид шилжүүлж, ... төрийн сангийн хэлтэст албан бичгээр мэдэгдэж байна. ...

² 2.7-д “Хэрэглэгчдийн нэр, нууц үгийг бусдад шилжүүлсэн тухай бүр ... “Хэрэглэгчийн нэр, нууц үг шилжүүлэх маягт” /хавсралт-1/-ын дагуу бүрэн гүйцэт, үнэн зөв хөтлөн харьяа нэгжийн даргаар баталгаажуулж холбогдох тушаал, шийдвэрийн хуулбарын хамт хавсарган архивын нэгж үүсгэнэ”

дутагдлаа хүлээн зөвшөөрөхгүй, аудитын байгууллагын гаргасан шийдвэрт үл хүндэтгэсэн байдлаар хандаж байна. ...

2.2 Төрийн сангийн нэгдсэн данс болон мөнгөн хөрөнгийн удирдлага, төсвийн хөрөнгийн хэрэгжилтийн талаар:

Төрийн сангийн хэмжээнд нийт 765 данс байршиж байгаагийн 273 данс нь сумдын орлогын данс, 19 нь аймгийн санхүү төрийн сангийн хэлтэс байрших төсвийн орлогын данс, 473 нь төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны данс байна.

Аймаг сумдын төсвийн орлогын дансны үлдэгдлийг холбогдох хууль, журамд заасны дагуу сар бүрийн эцэст ерөнхий дансанд хааж төвлөрүүлж байна.

Төрийн сангийн нэгдсэн дансыг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төв төрийн сан удирдан зохион байгуулна гэж Төсвийн тухай хуульд заасны дагуу аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс шаардлагатай шинээр нээх болон хаах дансны жагсаалтыг жил бүр гарган Сангийн яаманд хүргүүлэн түүнийг үндэслэн шаардлагагүй дансыг хаах шаардлагатай дансыг нээдэг байна. 2017 онд аймгийн хэмжээнд нийт 4 арилжааны банкны 14 дансыг хаалгах саналыг Сангийн яаманд хүргүүлэн ажилласан байна. Үүнд: Төрийн банкны 2, Хас банкны-1, ХААН банкны-10, Капитал банкны-1 хүргүүлсэн байна. /хавсралт 1/

Тайлант жилд төсөвт зохицуулалтыг холбогдох хууль журамд заасны дагуу аймгийн ИТХурлын 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 05 тоот тогтоолоор тодотгол хийж төсөвт байгууллагуудын жилийн төсвийн хуваарийг ТЭЗахирагчаар батлуулсан байна. Тогтоолоор орон нутгийн төсвийн зарлагыг 66,277.0 сая төгрөгөөр баталсан ба санхүүжилтийг батлагдсан төсвийн хуваарийн дагуу олгосон байна.

2.3 ЗГСУМС нь хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хэрхэн хангаж байгаа талаар:

Төрийн сангийн үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа ЗГСУМС-ийг аймгийн хэмжээнд нийт 44 хэрэглэгч ашиглаж байна. Уг системийн талаар 38 хэрэглэгчдээс санал асуулга авлаа. Санал асуулгын дүнгээр “ЗГСУМС хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгцээ шаардлагыг бүрэн хангасан эсэх” гэсэн асуултанд оролцогчид бүгд “*тийм*” гэж хариуллтыг өгсөн байна.

Өгөгдөл оруулах, боловсруулах, тайлан мэдээ гаргах явцад саатал бэрхшээл байдаг эсэх гэсэн асуултанд 1 хэрэглэгч заримдаа гардаг гэж хариулсан байна.

Харин хэрэглэгчдээс ирүүлсэн саналд Өдөр тутмын ажил гүйлгээг гүйцэтгэхэд хэрэглэгчээс үл шалтгаалан “зарим орлого, зарлагын гүйлгээг шивэхэд тухайн өдрийн орлого зарлагын дэлгэрэнгүй тайлан дээр гарч ирэхгүй дараа өдрийн орлого зарлагын дэлгэрэнгүй тайлан дээр гардаг мөртлөө тухайн өдрийн төсвийн багц дахь байгууллагын дансны үлдэгдлээс хасагдаж, нэмэгддэг системийн алдаа дутагдал гардаг гэжээ. дутагдалтай тал байдаг гэжээ.

Судалгаанаас үзэхэд ЗГСУМС-ийн аюулгүй байдалд учруулдаг болон болзошгүй эрсдэл, тохиолдолд гараагүй байна. Судалгаанаас үзэхэд ЗГСУМС-ийн аюулгүй байдалд ямар нэг аюул эрсдэл, тохиолдоогүй байна. Системийн функционал администратор журамд заасан хугацаанд тайлант үеийг өндөрлүүлж эхлүүлсэн, зохих эрхийг бүрэн олгосон, хэрэглэгчийн эрхийг хязгаарласан тохиолдол байхгүй, эрхийг давхардуулан ашигласан хэрэглэгч байхгүй байна.

Харин Системд нэвтрэх нэр, нууц үгийг Өгийнуур сумын төлбөр тооцооны мэргэжилтэн ARUG1, ARUG2 гэсэн эрхээр нэвтрэн гүйлгээ хийх, баталгаажуулах 2 эрхийг журам зөрчин ашиглаж байгаа нь аудитаар илэрсэн. Энэ нь ЗГСУМСистемд мөрдөх журмын 2.6³ дахь заалтыг дагаж мөрдөлгүй Өгийнуур сумын Төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэнд Санхүү албаны даргын эрхийг нээж өгсөнтэй холбоотой байна. Иймд аудитаас аймгийн СТСХэлтэст ЗГСУМС-ийн үйл ажиллагааг зохицуулж буй журмыг бүрэн хэрэгжүүлэх, түүнд тавих хяналтыг сайжруулах зөвлөмжийг хүргүүллээ.

2.4 Төрийн сангийн үйл ажиллагаанд хэрэгжүүлсэн дотоод хяналтын талаар:

Аймгийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн а/115 тоот захирамжаар Төрийн сангийн үйл ажиллагаанд хийх дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөөг батлуулсан ба төлөвлөгөөнд бүх сумдад болон аймгийн төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг 252 хоногт зайны хяналт хийхээр боловсруулсан байна.

Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн нь уг төлөвлөгөөний дагуу аймгийн Засаг даргын нэрэмжит шалгалттай хамтран 16 сумын Санхүүгийн албанд хяналтыг хийсэн байна. Хяналт шалгалтаар зөрчил их гарсан эрсдэлтэй Хотонт, Жаргалант, Хайрхан, Цахир, Цэнхэр, Булган, Төвшрүүлэх сумуудад зөрчил дутагдлыг арилгуулах зөвлөмж хүргүүлэн зөвлөмжийн мөрөөр биелэлтийг гаргуулан ажилласан байна.

³ ЗГСУМСистемд мөрдөх журмын ³2.6-д “Тухайн төсвийн жилийн системийн хэрэглэгч ажлаас чөлөөлөгдсөн, халагдсан тохиолдолд тухайн хэрэглэгчийн эрхийг хязгаарлах, шинэ хэрэглэгчийг бүртгүүлэх тухай албан хүсэлтийг ... сум, дүүргийн хэрэглэгчийн хувьд харьяа аймаг, нийслэлийн санхүү төрийн сангийн хэлтсээр дамжуулан, Төрийн захиргааны төв байгууллагын санхүү, хөрөнгө оруулалтын газар, хэлтэс холбогдох тушаал, шийдвэрийн хуулбарын хамт ирүүлнэ...”

Аймаг сумдын төрийн сангийн нэгжүүдэд Сангийн сайдын 2015 оны 65 дугаар тушаалаар батлагдсан эрсдэлийн үнэлгээний аргачлалын дагуу үнэлгээг хийхэд “Дунд” гэсэн үзүүлэлттэй гарсан байна.

Дотоод хяналтаар сумын төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн шууд захирагчийн төсөв санхүүгийн мэдлэг дутуугаас гаргаж байгаа шийдвэр нь хуульд нийцэхгүй, эрх зүйн үндэслэл муутай, санхүү албаны дарга, төрийн сангийн мэргэжилтний ажлын хариуцлага, ур чадвар дутмаг, ЗГСУМС-д мөрдөх журмын зөрчиж ЗГСУМС-д нэвтрэх эрхээ бусдад тушаал шийдвэргүйгээр шилжүүлдэг зэрэг зөрчлүүд илэрч тухайг зөрчлийг ариглах талаар зөвлөмж хүргүүлэн ажилласан байна.

2017 онд Төсвийн хэрэгжилт, мөнгөн хөрөнгийн удирдлагад тавих дотоод хяналт үр нөлөөг сайжруулахын тулд тайлант онд холбогдох байгууллагуудтай хамтран сумдын санхүү алба болон төсөвт байгууллагын нягтлан бодогч нарт төрийн сангийн дотоод хяналтаар илэрсэн алдаа зөрчлийг арилгах, цаашид төсвийн хэрэгжилт, мөнгөн хөрөнгийг удирдан зохион байгуулах, арга зүйгээр хангах сургалтыг явуулж, дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг арилгах талаар зөвлөмж хүргүүлэн, хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан байна.

АУДИТЫН ДҮН

Төрийн сангийн тогтолцоо үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитаар төрийн сангийн төлбөр тооцооны мэргэжилтэн шаардлага хангаагүй 988 ширхэг төлбөрийн хүсэлтээр гүйлгээ хийсэн, 659 ширхэг анхан шатны баримтанд хяналт тавьж тэмдэг дараагүй 1,625.8 сая төгрөгийн гүйлгээтэй холбоотой зөрчил илэрсэн. Аудитаас тухайн сумдад зөрчлийг арилгах албан шаардлагуудыг хураангуй тайлангийн хамт хүргүүлсэн. Мөн төрийн сангийн үйл ажиллагааны журам, ЗГСУМС-ийн журмуудыг тус тус зөрчсөн Жаргалант, Өгийнуур сумдын холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлээд байна.

Дээрхи зөрчил дутагдлыг таслан зогсоож, төрийн сангийн төлбөр тооцоонд мөрдөх журмын хэрэгжилтийг хангах талаар тодорхой арга хэмжээ зохион байгуулан ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүллээ.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

“Төрийн сангийн тогтолцоо үйл ажиллагааны үр дүнд” хийгдсэн аудитаар дараах дүгнэлтийг өгч байна.

- 1. Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагаанд мөрдөж буй хууль эрх зүйн заалтууд хоорондоо уялдахгүй байна.**
- 2. Төрийн сангийн төлбөр тооцооны журмын хэрэгжилт хангалтгүй байна.**

АУДИТААС ДАРААХ САНАЛЫГ САНГИЙН ЯАМАНД УЛАМЖИЛЖ БАЙНА

Төрийн сангийн тогтолцоо үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитаар мөрдөгдөж буй хууль эрх зүйн зарим заалтууд нь хоорондоо уялдахгүй байсан тул эрх зүйн орчинг сайжруулах саналыг холбогдох шийдвэр гаргах түвшинд уламжлуулан шийдвэрлүүлэх саналтай байна.

1. Засгийн газрын 2015 оны 11-р сарын 2-ны өдрийн 426 тоот тушаалаар батлагдсан “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоолын 2.1 дэх заалтыг хуульд нийцүүлэн өөрчлөлт оруулах.

Учир нь:

- Төсвийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 **“Энэ хуулийн 19.1, 19.2-т зааснаас бусад тохиолдолд төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагч, шууд захирагч нь төсвийн ахлах нягтлан бодогч, нягтлан бодогчтой байна”** гэж заасан, харин Засгийн газрын 426-р тогтоолын 2.1-т **“сумын ЗДТГ-ын санхүү алба нь дараах төсвийн байгууллагууд болон ОНХС, тусгай сангууд засаг даргын нөөц хөрөнгийг хариуцсан нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх 2 нягтлан бодогчтой байна”**, 2.2-д **“Хэрэв суманд дээр дурьдснаас олон орон тооны төсвийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бол ажлын ачааллыг харгалзан 3-5 төсвийн байгууллагын дунд 1 нягтлан бодогчтой байхаар орон тооны нормативыг тогтоох бөгөөд хариуцаж байгаа байгууллагуудын төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг хийж, тэдгээрт нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлнэ”** гэж заасан нь хуультай нийцэхгүй байна.
- 2. Сангийн сайдын 2014 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 95 тоот тушаалаар батлагдсан “Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх журам” – ын 5.9 дэх заалтад өөрчлөлт оруулах

Учир нь:

- Сангийн сайдын 95 тоот тушаалаар батлагдсан “Засгийн газрын удирдлагын мэдээллийн системд мөрдөх журам”-ын 3-т “системд нэвтрэх хэрэглэгчдийн ажил үүргийн ангилал”-ыг тусгайлан зааж өгсөн ба 5.9-д “журмын 3 дугаар зүйлд заасан эрхүүдийг нэг албан тушаалтанд давхардуулан олгохгүй бөгөөд өөрт оногдсон эрхээс өөр эрхээр системд нэвтэрч ажил үүрэг гүйцэтгэхийг хориглоно. **Журмын энэхүү заалт нь сумын санхүүгийн албаны албан**

тушаалтанд хамаарахгүй болно” гэсэн нь сумын Санхүү албаны дарга болон төрийн сангийн мэргэжилтний албан тушаалыг 1 хүн хийж болохоор зааж өгсөн байна. Энэ нь төсөв хөрөнгийн зарцуулалтанд хяналтын эрсдэл үүсгэх нөхцөл байдлыг бий болгож байна.

3. Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2 “ төв төрийн сан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аймаг, нийслэл, сум дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд байна” гэсэн заалтыг хэрэгжүүлэх

Учир нь:

- Өнөөдрийн байдлаар санхүү төрийн сангийн хэлтэс, нэгжүүд харьяа аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын дэргэд бус бүтэц орон тоонд багтаж ажиллаж байгаа нь Төрийн сан бодлого чиг үүргээ хэрэгжүүлэхэд хараат байдал үүсэх эрсдэл байж болох тул дээрх хуулийн дагуу бүтэц зохион байгуулалтыг нэг мөр шийдвэрлэх нь зүйтэй байна.

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2018.11.01

ЗӨВЛӨМЖ

Аймгийн Засаг дарга Ц. Мөнхнасан танаа

1. Аймгийн хэмжээнд Төрийн сангийн үйл ажиллагааны журмын хэрэгжилтийг ханган, сумдын санхүү албаны үйл ажиллагааг арга зүй, бодлого чиглэлээр хангаж ажиллах
2. Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, таслан зогсоох, аудитын мөрөөр тодорхой арга хэмжээ зохион байгуулах
3. Аймгийн СТСХэлтсээс сумдын санхүүгийн албаны төлбөр тооцоо, төрийн сангийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах
4. Сумдын Санхүү албаны ажилтнуудын ажлын ур чадвар, мэдлэгийг дээшлүүлэх, чадавхжуулах сургалт зохион байгуулах арга хэмжээ авч ажиллах

Дээрх зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажилласнаар аймагт болон сумдад Төрийн сангийн үйл ажиллагаа бүрэн хэрэгжиж Төсвийг үр ашигтай зарцуулах, түүнд тавих хяналт сайжирч бодит үр дүн гарна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



**МОНГОЛ УЛС
АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА**

65139 Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 2 дугаар баг,

Утас/Факс: (976) 7033 3208,

И-мэйл: arkhangai.gov@gmail.com,

Вэбсайт: www.arkhangai.gov.mn

2018. 11. 02 № 2/НББ

танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.УЛАМБАЯР ТАНАА

Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар
төрийн сангийн тогтолцоо үйл ажиллагаанд хийсэн
аудитын тайлантай танилцлаа.

Тайлангийн төсөлд өгөх санал байхгүй болно.



ОРЛОГЧ

Б.БОЛОРМАА

